

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.05.14-05.18

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын компаниудын хувьцаа харьцангуй бага хэмжээгээр арилжигдан, ханш нь долоо хоногийн турш өөр өөр үзүүлэлттэй байлаа. Эрчим хүчний салбарын компаниудын хувьцааны ханш өсөлт үзүүлсэн бол, үл хөдлөх хөрөнгийн салбарын болон өргөн хэрэглээний бараа үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш унасан. Урт хугацааны бондын өгөөж нэмэгдсэнээр эдгээр компаниудын ногдол ашгийн хуваарилалт анхаарал татахаа больсон байна.

Мягмар гаригт АНУ-ын эдийн засгийн тойм гарч, эдийн засаг сайжирсантай холбогдуулан бодлогын хүү өсөх магадлал нэмэгджээ. Ингэснээр хувьцаануудын ханш эрс унасан байна. АНУ-ын худалдааны яамны мэдээлсэнээр голлох жижиглэнгийн худалдаа 0.3 хувиар өслөө.

Эдийн засаг сайжирсан нь 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын өгөөжийг 3.12 хувиар өсгөв. Энэ нь сүүлийн долоон жил дэх хамгийн өндөр түвшин юм.

Европ: Европын компаниудын хувьцааны ханш долоо хоногийн турш ихээр хэлбэлзэн өсөлттэй хаагдаа.

Их Британи Brexit-ийн дараа Европын холбооноос худалдааны холбоогоо таслахгүй байхаар шийдвэрлэсэн явдал тус улсын FTSE 100 индексийг өсөхөд нөлөөлжээ.

Газрын тосны үнэ нэмэгдэж уул уурхай болон эрчим хүчний салбарын компаниудын хувьцааны ханш өсөв. Мэдээлэл, харилцаа холбоо болон банкуудын ашгийн хэмжээ бууран, тэдгээрийн хувьцааны ханш унасан байна.

Япон: Японы компаниудын хувьцааны ханш энэ долоо хоногт өслөө. Nikkei 225 индекс найм дахь долоо хоногоо дараалан өсөлттэй хаагдаж, 0.76% өсөн 22,930.36 нэгж хүрэв. АНУ-ын Засгийн газрын бондын өгөөж өсөн, ам. долларын ханш нэмэгдэж, иений ханш сулран 110.72 хүрлээ. Энэ нь 1-р сараас хойшхи хамгийн доод түвшин юм.

Япон улсын эдийн засгийн өсөлт 8 улирал дараалан өсч, энэ жилийн эхний улиралд тус өсөлт 0.6%-тай тэнцсэнээр дуусгавар болжээ. Тус 8 улирал дараалсан өсөлт нь сүүлийн 28 жилд тохиогоогүй удаан үргэлжилсэн үйл явдал байв. Суурь инфляцийн түвшин 4-р сард 0.7 хувьд хүрсэн нь зорилтот 2% түвшнээс бага байв.

БНХАУ: БНХАУ-ын худалдааны протекционист бодлого тус улсын эдийн засгийн өсөлтийг удаашруулах төлөвтэй байна.

Эхний 4 сарын байдлаар хотын бүсийн хөрөнгө оруулалт 1999 оноос хойшхи хамгийн бага өсөлтийг үзүүлжээ. Жижиглэнгийн худалдаа өмнөх оны мөн үеэс 9.4 хувиар өсөв. Аж үйлдвэрийн гарц 7.0 хувиар өссөн нь Хятад улсын агаарын бохирдолтой тэнцэх арга хэмжээ суларсантай холбоотой хэмээн үзлээ. Тус хугацаанд Хятад улсын эдийн засагт БНХАУ болон АНУ хоорондын худалдааны асуудал нөлөөлөөгүй хэмээн Хятад улсын статистикийн газар мэдээлжээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,213.17	-0.21% ▼
Dow Jones	АНУ	24,715.09	-0.47% ▼
S&P 500	АНУ	2,712.97	-0.54% ▼
Nasdaq	АНУ	7,354.34	-0.66% ▼
S&P/TSX	Канад	16,162.31	1.27% ▲
FTSE 100	Их Британи	7,778.79	0.70% ▲
S&P/ASX 200	Австрали	6,087.40	-0.47% ▼
Nikkei 225	Япон	22,930.36	0.76% ▲
Hang Seng	Хонг Конг	31,047.91	-0.24% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	109.17
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	96.26
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	95.54
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	112.30
Mongol CNY (Димсам)	CNY	7.5%	100.13
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.52
TDBM' 2020	USD	9.3%	106.18

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Үөү
Libor 1M	1.953	0.03 ▲
Libor 3M	2.329	-0.01 ▼
Libor 6M	2.499	-0.02 ▼
Libor 1YR	2.765	0.00 ▼
US 6M Bond	2.077	0.05 ▲
US 2YR Bond	2.557	0.02 ▲
US 3YR Bond	2.726	0.04 ▲
US 5YR Bond	2.902	0.07 ▲
US 10YR Bond	3.069	0.11 ▲

Валютын ханш /төг/

Валют	2018.05.18	Өөрчлөлт
USD	2,405.65	0.17% ▲
CNY	377.46	-0.29% ▼
EUR	2,842.03	-0.63% ▼
RUB	38.84	-0.15% ▼
KRW	2.23	-0.89% ▼
JPY	21.69	-1.27% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хаалт /USD/	Өөрчлөлт
Алт /spot/	1,293.05	-2.18% ▼
Мөнгө /spot/	16.44	-1.67% ▼
Эс	306.35	-1.76% ▼
Нүүрс	104.10	4.36% ▲
WTI газрын тос	71.28	0.83% ▲
Brent газрын тос	78.51	1.83% ▲
Байгалийн хий	2.85	1.06% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018.III	6.60%
Бодлогын хүү	2018.III	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018.III	10.07%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018.III	12.80%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018.III	5.20%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018.III	19.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2018.III	11.30%

Эх сурвалж: Үндэсний статистикий хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 102 компанийн 394.1 сая төгрөгийн 4,061,994 ширхэг хувьцаа арилжигдав.

“Алтайн зам” /AZH/ компанийн хувьцаа 32.25%-аар буюу хамгийн ихээр өсч 798.5 төгрөгт хүрч хаагдсан бол “Мон-Ит Булигаар” /MBG/ компанийн хувьцаа 14.95%-аар буурч 9,270 төгрөгт хүрч хаагдлаа.


Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр 1 удаагийн хэлцлээр нийт 4,000 ширхэг үнэт цаас 416.9 сая төгрөгөөр арилжаалагджээ.

Компанийн бондын хувьд хоёрдогч зах зээл дээр 2,025 ширхэг үнэт цаас 202.5 сая төгрөгөөр арилжигдсан байна.


5-р сарын 18-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,366.9 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,213.17 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.21%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: MSE

Арилжааны үнийн дүн /7 хоногоор/



Эх сурвалж: MSE

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	1,175.9
Зах зээлийн үнэлгээ	2,366,900.9

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,213.17	-0.21% ▼
MSE I индекс	9,065.86	-1.89% ▼
MSE II индекс	10,190.15	3.78% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛендМН ББСБ	3,780,761	178,270,027
АПУ	245,211	141,749,010
Таван Толгой		97,123,275
Говь		40,794,140
Сүү	112,092	23,141,178

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Алтайн зам	798.50	32.25% ▲
Тээвэр-Ачлал	920.00	15.00% ▲
Стандарт ноос	575.00	15.00% ▲
Могойн гол	9,200.00	15.00% ▲
Блюскай секьюритиз	2,070.00	15.00% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Мон-Ит Булигаар	9,270.00	-14.95% ▼
Хай Би Ойл	56.18	-14.88% ▼
Силк нет	630.00	-14.24% ▼
Авто импекс	2,190.00	-12.40% ▼
Ремикон	42.00	-10.66% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ Эссет Секьюритис Монгол	189,655,597
Ти Ди Би Капитал	135,834,968
БиДиСек	132,152,973
Бумбат-Алтай	126,759,115
Стандарт инвестмент	111,178,504

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	564.38	600,603
Таван толгой	9,330.00	491,366
МИК	10,510.00	217,655
Говь	21,500.00	167,724
Сүү	210.65	72,464

ЗГҮЦ-НЫ АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-04/07/19-A0266-14.82	4,000	416,880,000	103,950	104,490	104	14.820%

КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

Компанийн бондын хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	SUUB-BD-29/06/18-C0006-17.5	2,025	202,500,000	100,000	100,000	52	17.500%

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төгрөг/	Нийт ногдол ашиг /сая төгрөг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	ERS	Монгол алт ХК	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
2	TEE	Тээвэр дархан ХК	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
3	TTL	Таван Толгой ХК	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.04.27-с
4	EER	Ариг гал ХК	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с
5	BDL	Могойн гол ХК	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	-
6	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
7	TAL	Талын гал ХК	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
8	AND	Анд-Энерги ХК	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	-
9	SUL	Жуулчин дюти фрий ХК	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
10	GTL	Гутал ХК	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
11	BNG	Баянгол зочид буудал ХК	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
12	APU	АПУ ХК	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.06.01-ний дотор
13	BTG	Баянтээг ХК	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
14	MIE	Материалимпекс ХК	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.12.31-ний дотор
15	HRD	Хүрд ХК	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор
16	SUU	Сүү ХК	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.05.21-с
17	MNP	Монгол шуудан ХК	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.05.01-с
18	MMX	Махимпекс ХК	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
19	TCK	Талх чихэр ХК	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
20	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	-	-
21	ADL	Адуун чулуун ХК	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	-
22	TAH	Тахь-ко ХК	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
23	UBH	Улаанбаатар хивс ХК	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
24	GOV	Говь ХК	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с
25	HRM	Гермес центр ХК	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.03.06-с

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Монгол базальт” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалгын хуваарилалтанд өөрчлөлт орлоо

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 5/2342 тоот албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу “Монгол Базальт” ХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй хувьцааг анхдагч зах зээлд арилжаалах хуваарилалтын төлөвлөгөөнд өөрчлөлт орсон байна.

Үүний дагуу анхдагч зах зээлийн худалдан авах захиалгын хэмжээ нийлүүлэлтээс давсан тохиолдолд дараах хүснэгтэд заасны дагуу хөрөнгө оруулагчдын тооноос хамааран харгалзах хэмжээг 100 хувь биелүүлж, түүнээс дээш гарсан мөнгөн дүнд хувь тэнцүүлэн хуваарилахаар боллоо.

Суурь хуваарилалт хийх мөнгөн дүн: 1.0 тэрбум төгрөг.

Биелэх мөнгөн дүн: Нийт захиалга өгсөн хүний тооноос хамаарна.

Хувь тэнцүүлэгдэх мөнгөн дүн: 5.4 тэрбум төгрөг.

Биелэх мөнгөн дүн: Нийт захиалгын мөнгөн дүнд харьцуулж, хувь тэнцүүлнэ.

Эх сурвалж: MSE.mn

“Монгол базальт” ХК-ийн гадаад хөрөнгө оруулагчид хуваарилалтын нөхцлийн дагуу арилжаанд оролцоно

Монголын хөрөнгийн биржид шинээр бүртгэгдсэн “Монгол Базальт” ХК-ийн туслах андеррайтераар ажиллаж байгаа “Гаули ҮЦК” ХХК нь “Монгол Базальт” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжаанд БНСУ-ын хөрөнгө оруулагчдаас хөрөнгө татан төвлөрүүлж байгаа бөгөөд тухайн харилцагчид нь “Монгол Базальт” ХК-д урт хугацааны хөрөнгө оруулах сонирхолтой байгаагаа илэрхийлж, Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн хуваарилалтын дагуу анхдагч зах зээлийн арилжаанд оролцох болсныг мэдээлсэн байна.

Хамгийн сүүлийн буюу баасан гарагийн байдлаар нийт хоёр тэрбум 600 сая орчим төгрөгийн захиалга иржээ.

Эх сурвалж: MSE.mn



“Монгол алт” ХК ногдол ашиг тараахаар боллоо

“Монгол Алт” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн №02 тоот тогтоолоор компанийн 2017 оны цэвэр ашгийн дүнгээс нэгж хувьцаанд 150 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөр тогтоож, ноогдол ашгийг 2018 оны 12 дугаар сарын 31-ний дотор олгохоор шийдвэрлэсэн байна.

Эх сурвалж: MSE.mn

“Жинст Увс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Жинст Увс” ХК нь 2018 оны 4 дугаар сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаараа “Жинст Увс” ХК-д “Ард санхүүгийн нэгдэл” хаалттай ХК-ийг нэгтгэхээр шийдвэрлэсэн байна.

Үүнтэй холбогдуулан энэхүү асуудлын эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.11-д заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрх үүслээ.

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн огноо: 2018 оны 4-р сарын 28-ны өдөр.

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх дуусах огноо: 2018 оны 6-р сарын 15-ны өдөр.

Шаардах эрхийг хэрэгжүүлэх нэгж хувьцааны үнэ: 1,547 төгрөг.

Эх сурвалж: MSE.mn

“Тээвэр дархан” ХК ногдол ашиг тараахаар боллоо

“Тээвэр Дархан” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн №02 тоот тогтоолоор компанийн 2017 оны цэвэр ашгийн дүнгээс нэгж хувьцаанд 500 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөр тогтоож, 2018 оны 12 дугаар сарын 31-ний дотор олгохоор шийдвэрлэсэн байна.

Эх сурвалж: MSE.mn

МХБ: Барилгын компаниуд 6-р сарын 30-наас ногдол ашгаа олгож эхэлнэ

Монголын Хөрөнгийн биржийн III ангилалд бүртгэлтэй “Барилга корпораци” ХК-ийн 2017 оны борлуулалтын орлогын 74 хувийг “Оюу Толгой”-ийн төслийн орлого дангаараа бүрдүүлсэн байна. “Барилга корпораци” ХК 2017 онд 397 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаас 10-13 хувийг ногдол ашиг болгон тараана гэж тус компанийн Гүйцэтгэх захирал мэдээлж байсан юм. Үүнээс гадна Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Ариг гал”, “Хүрд” зэрэг барилгын компаниуд 2017 оны цэвэр ашгаас ногдол ашгаа зарлаад байгаа бөгөөд ирэх зургаадугаар сарын 30-наас эхлэн тараахаар байгаа аж.

Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр энэ оны эхний улиралд урьдчилсан гүйцэтгэлээр барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 248 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүнээс 86.3 хувийг дотоодын барилгын байгууллага, 13.7 хувийг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэжээ. Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ эхний улиралд өмнөх оны мөн үеэс 22.3 хувиар өссөн байна. Үүнд дотоодын байгууллагын гүйцэтгэсэн ажлын хэмжээ 15.4 тэрбум төгрөгөөр буюу 7.8 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн талаар Үндэсний статистикийн хороо мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Багануур”, “Шивээ-Овоо” компанийн санхүүгийн хүндрэлийг шийдвэрлэнэ

Засгийн газрын ээлжит хуралдаанаар “Багануур”, “Шивээ-Овоо” компанийн санхүүгийн хүндрэлийг шийдвэрлэхээр болсон байна. “Монгол нүүрс” төслийн хүрээнд Дэлхийн банк болон Япон улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт зээлсэн өр төлбөрөөс “Багануур”, “Шивээ-Овоо” компанийн зээлийн үндсэн болон тохируулгын төлбөр болох нийт 110 тэрбум 700 гаруй сая төгрөгийг тухайн нүүрсний уурхайд оруулсан хөрөнгө оруулалт болгон тооцох боломжийг судалж шийдвэрлэхээр болсон байна.

“Багануур”, “Шивээ-Овоо” компанийн богино хугацаат өрийг дотоод нөөц бололцоогоо ашиглан зургаадугаар сарын нэгэн гэхэд эцэслэхийг “Эрдэнэс Монгол”, “Эрдэнэс Тавантолгой” компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд Засгийн газраас даалгажээ. Мөн нүүрсний үнийг бодит өртөгт хүргэж, нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттай авахыг салбарын сайд болон агентлагийн даргад үүрэг болголоо.

Эх сурвалж: BloombergTv.mn

ҮСХ: Нүүрсний экспорт III сараас хойш огцом нэмэгдэж, IV сард 3.56 сая тонныг экспортолсон

2018 оны эхний дөрвөн сард нийт экспортын 85 хувийг эрдэс бүтээгдэхүүний экспорт бүрдүүлсэн байна. Ялангуяа нүүрсний экспорт гурван хувиар нэмэгдэж, 795.8 сая ам.доллар болсон талаар Үндэсний статистикийн хороо мэдээллээ.

Нүүрсний экспорт гуравдугаар сараас хойш огцом нэмэгдэж, дөрөвдүгээр сард 3.56 сая тонныг экспортолсон байна. Ерөнхий сайд У.Хүрэлсүх дөрөвдүгээр сард БНХАУ-д айлчлах үеэр Ганцмодны боомтын нүүрсний гарцыг гурав болгон нэмэгдүүлсэн юм. Ингэснээр Гашуунсухайт-Ганцмодны боомтоор өдөрт дунджаар 950-1,200 орчим автомашин нүүрс тээвэрлэн гаргаж байгаа талаар “Эрдэнэс Тавантолгой” ХК мэдээллээ.

Үүнээс гадна оны эхний дөрвөн сард зэсийн баяжмалын экспорт биет хэмжээгээрээ 8.6 хувиар буурч, 458.6 мянган тонн болсон байна. Харин мөнгөн дүнгээр энэ нь 627.6 сая ам.доллар болж, 2017 оны мөн үеэс 20 хувиар өссөн талаар Үндэсний статистикийн хороо мэдээллээ. Гол экспортлогчдын нэг “Оюу Толгой” ХХК энэ оны эхний улиралд 168.9 сая ам.долларын борлуулалтын орлого олсон нь жилийн өмнөхөөс 13 хувиар буурсан талаар “Turquoise Hill Resources” компани мэдээлсэн юм. Үүнд баяжмалын агууламж буурсан зэрэг нь нөлөөлсөн гэжээ.

Харин цайрын экспорт оны эхний дөрвөн сард 41.6 мянган тонн болж, долоон хувиар өссөн байна. Мөнгөн дүнгээрээ 30 хувиар нэмэгдэж, 75.1 сая ам.доллар болжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Монголбанк 3290.6 кг алт худалдан авчээ

“Алт-2” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр алт тушаалт нэмэгдсэн байна. Өнгөрсөн дөрөвдүгээр сарын 31-ний байдлаар Монгол банк 988.8 кг алтыг худалдан авчээ.

Тодруулбал Төвбанк эхний дөрвөн сарын байдлаар 3290.6 кг алт худалдан авсан нь өмнөх оны мөн үеэс 257.6 кг-аар нэмэгджээ.

Монгол банк Лондонгийн үнэт металлын захын ханшаар алт худалдан авч байгаа бөгөөд грамм алт 102 мянга 96 төгрөгийн ханштай байна.

Эх сурвалж: Montsame.mn

ЭТТ ХК: “Chalco”-д борлуулах нүүрсний үнийг тонн тутмыг нь 60 ам.доллар болгож нэмсэн

“Эрдэнэс Таван Толгой” ХК “Chalco”-д нийлүүлж байгаа зүүн Цанхийн нүүрснийхээ тонн тутмын үнийг 70 центээр нэмэгдүүлж, 60 ам.доллар болгохоор тохиролцлоо. Улмаар үнээ 61.35 ам.долларт хүргэх “Эрдэнэс Таван Толгой” ХК-ийн саналыг “Chalco”-ийн тал нягталж үзээд ТУЗ-дөө танилцуулсны дараа энэ долоо хоногт багтаан хариу өгөхөөр шийдвэрлэжээ. “Эрдэнэс Таван Толгой” ХК-ийн баруун Цанхийн коксжих нүүрсийг уурхайн аман дээр тонныг нь 68.1 ам.доллараар, эрчим хүчний нүүрсийг 12-16 ам.доллараар борлуулж байгаа талаар мэдээлсэн юм. “Chalco” компанитай 2011 онд байгуулсан гэрээнийхээ дагуу зах зээлийн нөхцөл байдлаас хамаарч улирал тутам үнээ өөрчилж байх механизм буюу үнийн индекс тооцох аргачлалыг илүү сайжруулахаар зорьж байгаа аж.

Энэ хүрээнд “Эрдэнэс Таван Толгой” ХК-ийн төлөөлөл өнгөрсөн долоо хоногт “Chalco Tradin Hongkong” компанитай уулзалт хийжээ. Уулзалтын дүнд нэг индекс нэмж оруулснаар таван индексээр үнээ тооцох болсон байна. Ингэснээр өмнө нь “Ct China Coking Coal Price Index”-ээс 60 хувь хараат байсан нь 30 хувь болж буурчээ. Энэ нь 1-1.5 жилийн дотор баруун Цанхийн нүүрстэй ойролцоо үнээр зүүн Цанхийн нүүрсийг борлуулах, үнийн хэт савлагаа үүсэх эрсдэлээс сэргийлэх зэрэг давуу талтай гэдгийг “Эрдэнэс Таван Толгой” ХК мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



Монголын компаниуд нүүрсний экспортын үнээ нэмэхээр зорьж байна

БНХАУ-ын Засгийн газрын бодлоготой уялдуулж Монголын компаниуд экспортолж байгаа нүүрсний ханшаа нэмэгдүүлэхээр зорьж байгаа аж. “Тавантолгой”-ийн бүлэг ордод олборлолт хийж буй компаниудаас “Эрдэнэс Тавантолгой” ХК өнгөрсөн долоо хоногт хэлэлцээ хийж, Зүүн Цанхийн нүүрсийг нэг тонн тутмыг нь 60 ам.доллараар “Chalco”-д нийлүүлж байна. Мөн Баруун Цанхийн коксжих нүүрсийг 68 ам.доллараар, эрчим хүчний нүүрсийг 14-16 ам.доллараар уурхайн аман дээр худалдаж байгаа ажээ.

Үүнээс гадна “Mongolian Mining Corporation” санхүүгийн тайландаа “Угаасан нүүрсний борлуулалтын дундаж үнэ нэг тонн тутамд дунджаар 130.3 ам.доллар байна” гэжээ. Харин Нарийн Сухайтын бүлэг ордод олборлолт хийж буй “МАК”, “Өсөх зоос”, “Southgobi Sands” компаниуд нүүрсээ баяжуулж гаргахаар зорьж байгаа аж. “Southgobi Sands” ХХК-ийн хувьд нүүрсээ баяжуулснаар ханшийг нь тонн тутамд 500-600 юаньд хүргэнэ гэж тооцоолжээ. Тус компани 2018 онд 800 мянган тонн баяжуулсан нүүрс экспортлохоор төлөвлөсөн байна. Харин I улиралд нэг тонн нүүрсийг дунджаар 43.02 ам.доллараар борлуулсан нь 2017 оны мөн үеэс 1.7 дахин нэмэгдсэн талаар санхүүгийн тайландаа дурдсан байна.

Харин “МАК” буюу Монголын алт корпораци нэг тонн нүүрсийг уурхайн аман дээр 500 орчим юаниар борлуулж байгаа талаар сүүлд мэдээлсэн юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

ЗГ: 2024 он гэхэд зээлийн хүүний түвшнийг 16 хувь болгон бууруулна

Зээлийн хүүг захиргаадалтын бус аргаар бууруулж, 2024 он гэхэд 16 хувь болгохоор зорьж байгаагаа Засгийн газар мэдээллээ.

Энэ хүрээнд нийт санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувийг 12 хувьд хүргэж өсгөнө гэж онцолсон юм. Монголбанкны мэдээлснээр арилжааны банкнуудын зээлийн дундаж хүү 2018 оны гуравдугаар сарын байдлаар 19.1 хувьтай байгаа аж. УИХ-ын гишүүн С.Эрдэнэ Зээлийн хүүд дээд хязгаар тавих хуулийн төслийг өргөн бариад байгаа юм. Харин Монголбанк зээлийн хүүг зах зээлийн зарчмаар буулгах ёстой гэсэн байр суурь баримталж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



Ойрын 3 жилд нийслэлд 38.5 мянган айлын орон сууц ашиглалтад орох төлөвтэй байна

“Тэнхлэг зууч” компанийн судалгаагаар ирэх таван жилийн хугацаанд нийслэлд 217 мянган айлын орон сууцны хэрэгцээ бий болохоор байна. Харин орон нутагт 122 мянган айлын орон сууцны эрэлт үүсэх төлөвтэй байгаа аж. 2017 оны байдлаар нийслэлд амьдарч байгаа 380 мянган өрхийн 43 хувь нь инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдарч байна. Монголын Барилгын үндэсний ассоциаци, “Тэнхлэг зууч” ХХК хамтран улсын хэмжээнд орон сууцны зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг танилцууллаа.

Энэхүү судалгааг Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар гүйцэтгэжээ. Судалгаагаар Улаанбаатар хотод 62.3 мянган айлын орон сууцны 427 төсөл хэрэгжиж байна. Үүнээс ойрын гурван жилд нийслэлд 38.5 мянган айлын орон сууц ашиглалтад орох төлөвтэй байгаа юм. Харин зах зээлд 5822 айлын орон сууц бэлэн борлуулагдаж байгаа ажээ. Үүнээс дийлэнх нь 80 ам метрээс доош талбайтай, ам метр талбайн дундаж үнэ нь хоёр сая 114 мянган төгрөг байна. 2017 оны дөрөвдүгээр сарын байдлаар нэг ам метр нь хоёр сая 30 мянган төгрөг байжээ. Өөрөөр хэлбэл дундаж үнэ өнгөрсөн оны мөн үеэс бага зэрэг өсөөд байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

ҮСХ: 2018 оны 4-р сарын эдийн засгийн байдлын бураангуй

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2018 оны эхний улиралд урьдчилсан гүйцэтгэлээр 3.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 188.0 (6.1%) тэрбум төгрөгөөр өслөө. Уг өсөлтөд үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 74.8 (4.9%) тэрбум төгрөг (бөөний болон жижиглэн худалдааны салбарын нэмэгдэл өртөг 25.8 тэрбум төгрөг буюу 7.3%), бүтээгдэхүүний цэвэр татвар 56.8 (16.1%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2018 оны 4 дүгээр сарын эцэст 16.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 150.0 (0.9%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 3.8 (30.1%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2018 оны 4 дүгээр сарын эцэст 937.6 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 97.1 (11.6%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 103.4 (12.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2018 оны эхний 4 сард 2.5 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2.4 их наяд төгрөг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 98.2 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ашиг өмнөх оны мөн үеэс 204.0 тэрбум төгрөгөөр өсөхөд орлогын өсөлт зарлагын өсөлтөөс 10.2 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ.

Монгол Улс 2018 оны эхний 4 сард дэлхийн 125 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 3.7 тэрбум америк доллар, үүнээс экспорт 2.1 тэрбум америк доллар, импорт 1.6 тэрбум америк долларт хүрлээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 4 дүгээр сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.6 хувь, өмнөх оны эцсээс 3.8 хувь, өмнөх оны мөн үеэс 6.0 хувиар өссөн байна.

Харин импортын өсөлтийн гол шалтгаан нь эрдэс бүтээгдэхүүний импорт болсон байна. Эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл бүтээгдэхүүн, үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн экспорт нийт экспортын 95.3 хувийг эзэлж байгаа юм.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 6.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 6.1 хувь (төмс, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 24.3 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 5.7 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 9.3 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 8.5 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 6.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 13.0 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 23.0 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 9.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Эх сурвалж: NSO.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээжгүй болно.